

“АПУ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 26 -ны өдөр

Дугаар 19/01

Улаанбаатар хот

APU COMPANY ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛУУДЫГ БАТЛАХ ТУХАЙ

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэр, Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. АПУ ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж баталсугай.
2. АПУ ХК-ийн Дүрэмд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулж, хавсралтаар баталсугай.
  1. 7.6. Дор дурьдсан асуудлыг энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.  
7.6.2. Компанийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.5-д зааснаас бусад нэгтгэх, нийлүүлэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
  2. 7.16. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдахгүйгээр Хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болно. Харин хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно. Эчнээ санал хураалтыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу явуулна. Ээлжит хурлыг болон доорхи асуудлыг шийдвэрлэх хурлыг эчнээ санал хураалтаар явуулахыг хориглоно. Үүнд Компанийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.5, энэхүү дүрмийн 7.22.21-т заасны дагуу нэгтгэх замаар өөрчлөн байгуулах асуудал хамаарахгүй болно.  
7.16.1. Компанийн Дүрмийг өөрчлөх, шинэчилсэн найруулгыг батлах;  
7.16.2. Компани нийлүүлэх, нэгтгэх, хуваах, татан буулгах, зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх;
3. 7.22. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ дүрмээр Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

7.22.21. Компанийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.5-д заасны дагуу компани нийт энгийн хувьцааны 75 хувиас дээш хувийг эзэмшдэг өөрийн охин компаниа нэгтгэх, ийнхүү нэгтгэснээр компанийн дүрэмд өөрчлөлт орох шаардлагагүй тохиолдолд уг компанийг нэгтгэх тухай шийдвэр гаргаж, нэгтгэх журмыг батлах;

4. Өөрчлөгдсөнөөс бусад дүрмийн зүйл, заалтууд хэвээр болно.
  5. Дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэгт даалгасгай.
3. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгосугай.
  4. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дараах бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаатайгаар сонгосугай.

Ердийн гишүүн

1. П.Батсайхан
2. Кеннет Чу
3. Б.Батбаяр
4. Я.Дамдинсүрэн
5. С.Б.Громов
6. Томас Холланд

Хараат бус гишүүн

7. Ж.Үнэнбат
8. Ё.Гэрэлчулуун
9. Ө.Батбаяр

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЭРДЭНЭБИЛЭГ